

“МОНГОЛ УЛС ХИЙГЭЭД ХӨРШ ОРНУУДЫН ХАРИЛЦААН ДАХЬ ШИНЭ ӨРНӨЛ”

Ж.Баясах¹

Mongolia signed the comprehensive strategic partnership agreement with the both direct neighbors: China and Russia. So the trilateral relationship during recent years reached the high level development since 2014 till today. We signed that type relationship at the beginning of April of this year when the Russian foreign minister Sergei Lavrov visited Mongolia. The basic document of bilateral relationship with two direct neighbors is the agreement of cooperation and friendly relationship which signed with the Russian Federation at 1993 and with the PRC at 1994.

Mongolia and its President of Mongolia Ts.Elbegdorj was an initiator of the trilateral President's Meeting which already happened three times and we will have the fourth meeting at Tashkent during SCO leaders meeting at Uzbekistan by the end of June of 2016. The relationship of three states developed successfully and reached the high level which never reached before at their history.

Last year September the Mongolian President Ts.Elbegdorj announced that Mongolia will provide the neutrality foreign policy and noted Mongolia will use the previous agreement and treaty which were signed with the foreign states as like before and will develop the third neighbor foreign policy.

Монгол Улсын хойд хөрш дэлхийн хамгийн том газар нутагтай, цөмийн зэвсэгтэй сэргэн мандаж буй гүрэн бол, урд хөрш дэлхийн хамгийн олон хүн амтай, цөмийн зэвсэгтэй, үсрэнгүй урагшилж буй эдийн засагтай хамгийн том хөгжиж буй орон, мөн хоёул өөрсдийн бие даасан онцлог бодлого, байр суурьтай их гүрнүүд юм. Монгол Улс ийм өвөрмөц геополитикийн байршилтай цорын ганц орон гэж хэлж болно.

¹ Ж.Баясах. ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн захирал, профессор, доктор Sc.D
e-mail: bayasakhjk@gmail.com

2012 оны 11 дүгээр сард хуралдсан ХКН-ын XVIII их хурал Хятад улсын 100 жилийн ойгоор буюу 2049 он гэхэд баян чинээлэг, хүчирхэг, ардчилсан, соёл иргэншил бүхий төгс шинэчлэгдсэн социалист улс болно гэдгийг зарлав. Хятад улс бол «дэлхий дээрх хамгийн том хөгжиж буй орон» хэмээн дүгнэв.

Монгол Улс хоёр хөрштэйгөө тэнцвэртэй харилцах гадаад бодлогын тэргүүлэх зарчмыг удирдлага болгон ОХУ-тай 2003 онд «*Сайн хөршийн уламжлалт түншлэл*», 2009 онд «*Стратегийн түншлэл*», БНХАУ-тай 2003 онд «*Сайн хөршийн харилцан итгэсэн түншлэл*», 2011 онд «*Стратегийн түншлэл*»-ийн харилцааны эрхзүйн үндсийг тавив.

2011 оны 2 дугаар сард шинэчлэн батлагдсан “Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал”-д «ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ» гэж заасан нь 1994 оны Гадаад Бодлогын заалтыг дахин нотолсон хэрэг юм.

Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайдын урилгаар 2011 оны 6 дугаар сард БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр гаргасан Бээжингийн “Хамтарсан Тунхаглал”-д хоёр орны харилцааны цаашдын чиг хандлагыг *стратегийн түншлэлийн харилцаанд тулгуурлан хөгжүүлэхээр* шийдвэрлэв. Үүнд: Улс төрийн хэлхээ холбоо, харилцан итгэлцлийг нэмэгдүүлэх замаар Монгол, Хятадын стратегийн түншлэлийн харилцааны улс төрийн үндсийг хэлбэрэлтгүй бэхжүүлэхээр заажээ. Монгол Улстай найрсаг харилцаа хөгжүүлэх нь БНХАУ-ын Засгийн газрын стратегийн тууштай чиг шугам болохыг Хятадын тал нотолсон бол, БНХАУ-тай найрсаг харилцаа, хамтын ажиллагааг бүх талаар өргөжүүлэн хөгжүүлэх нь Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг болохыг Монголын тал нотолсон байна. Эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг өргөжүүлэн гүнзгийрүүлж, харилцан ашигтай, хамтаар хожих хамтын ажиллагааг тогтвортой хөгжүүлж, хамтын хөгжлийг урагшлуулах нь Монгол, Хятадын стратегийн түншлэлийн харилцааны өнө удаан хугацааны хөдөлгөгч хүч байх болно гэжээ.

2013 оны 10 дугаар сарын 25-нд Бээжинд хоёр улсын Ерөнхий сайд нарын гарын үсэг зурсан «Монгол Улс, БНХАУ-ын хооронд Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр» нь хамтын ажиллагаагаа тодорхой салбаруудаар хэрэгжүүлэх газрын зураг болж байгаа юм.²

Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн урилгаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын дарга Ши Жинь Динь 2014 оны 8 дугаар сард Монгол Улсад төрийн айлчлал хийж, Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржтой өргөтгөсөн хэлэлцээ хийж, энэ үеэр хоёр улсын тэргүүн Монгол, Хятадын харилцааг ***Иж бүрэн түншлэлийн стратегийн харилцаанд хүрсэн хэмээн дүгнэж***, уг харилцааг хөгжүүлэх тунхаглалд гарын үсэг зурсан нь³ энэхүү айлчлалын хамгийн чухал үйл явдал болсон юм.

Талууд Монгол, Хятадын харилцааны өндөр түвшинд хөгжиж буй таатай үндэс суурь болон бодит шаардлагад үндэслэн, хоёр улс, хоёр ард түмний нийтлэг эрх ашигт нийцсэн стратегийн түншлэлийн харилцааг улам бүр гүнзгийрүүлэх хамтын хүсэл эрмэлзлийн дагуу мөнхөд итгэлтэй, хариуцлагатай сайн хөрш, сайн түнш, сайн нөхөр байхын тулд Монгол, Хятадын стратегийн түншлэлийн харилцааны түвшинг дээшлүүлэн Монгол, Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоохоор санал нэгтгэйгээр тохиролцов.

Олон улсын нөхцөл байдалд ямарч өөрчлөлт гарсан хоёр улс нь харилцааны гол чиг шугамаа дагаж, стратегийн түншлэлийн өнцгөөс нөгөө талынхаа эрх ашгийг бодолцож байх ёстой. Нөгөө талын бүрэн эрх, аюулгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал зэрэг гол асуудал болон нөгөө талынхаа анхаарлаа хандуулж буй томоохон асуудалд тууштай, харилцан дэмжлэг үзүүлж байх хэрэгтэй.

Хоёр улсын удирдагч нар янз бүрийн шугамаар уулзалдаж, стратегийн зохицуулалтыг эрчимжүүлж, улс төрийн харилцан итгэлцлийг бэхжүүлнэ.

² Монгол Улс, БНХАУ-ын хооронд Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх Дунд, Урт хугацааны Хөтөлбөр. УБ.: 2013.10.25

³ Монгол Улс, БНХАУ-ын хооронд Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан Тунхаглал. УБ.: 2014.08.21

Талууд “Монгол, Хятадын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай 1994 оны гэрээ” болон бусад баримт бичгийн үзэл санааны дагуу бие биеийн тусгаар тогтнол, бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх, харилцан үл довтолох, хүч үл хэрэглэх, дотоод хэрэгт үл оролцох, эрх тэгш, харилцан ашигтай байх, энх тайвнаар зэрэгцэн орших, тус тусын сонгосон хөгжлийн замыг харилцан хүндэтгэх зарчмын үндсэн дээр найрсаг хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхээр болов.

Талууд нөгөө талын бүрэн эрх, аюулгүй байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдалд хохирол учруулах аливаа үйл ажиллагаа явуулахгүй, аливаа гэрээ байгуулахгүй, аливаа эвсэл, бүлэглэлд нэгдэхгүй, тэдгээрийн нөгөө улсын эсрэг чиглэсэн үйл ажиллагаанд оролцохгүй, нөгөө талын бүрэн эрх, аюулгүй байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдалд хохирол учруулах үйл ажиллагаа өөрийн улсын нутаг дэвсгэрт явуулахыг аль нэг гуравдагч улс, байгууллага, бүлэглэлд зөвшөөрөхгүй байхыг онцлон тэмдэглэв.

Талууд хоёр улсын уламжлалт найрсаг харилцааг тогтвортой, харилцан ашигтай, харилцан хүндэтгэх зарчимд тулгуурлан хөгжүүлэх нь өөрийн улсын гадаад бодлогын тэргүүлэх, стратегийн чиглэлийн нэг болохыг дахин нотлов.

БНХАУ хөрш орнуудтайгаа “илүү дотно, чин сэтгэлээсээ, харилцан ашигтай хүртээмжтэй байх” зарчмын дагуу хөгжлийн үр дүнгээ хуваалцан, харилцан ашигтай хамтдаа хожих бодлого баримталж байгааг Монголын тал өндрөөр үнэлэв. Энэхүү зарчим нь Монгол, Хятадын харилцаа болон бүс нутгийн хамтын ажиллагааны хөгжилд илүү таатай боломжийг бүрдүүлж байгааг талууд тэмдэглэв.

Монголын тал БНХАУ-ын Засгийн газар нь нийт Хятадыг төлөөлөх цорын ганц хууль ёсны Засгийн газар гэж үздэгээ нотлов. Монголын тал Тайвань, Төвд, Шинжааны асуудлаарх Хятадын талын байр суурийг тууштай дэмжихээ нотлов.

Талууд хоёр улсын өндөр, дээд түвшний харилцан айлчлалын давтамжийг хадгалж, олон улсын арга хэмжээний үеэр уулздаг уламжлалыг үргэлжлүүлж, бусад арга хэлбэрийг ашиглан стратегийн хэлхээ холбоогоо улам бэхжүүлнэ.

Хамтарсан Тунхаглалд орсон нэг шинэ зүйл бол талууд Гадаад хэргийн яамдын хооронд “Стратегийн яриа хэлэлцээ”-ний механизмыг байгуулж, хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа, гадаад бодлого болон олон улс, бүс нутгийн хүрээн дэх харилцан сонирхсон асуудлаар тогтмол санал солилцож байхаар тохиролцсон явдал болно.

“Хамтарсан Тунхаглал”-д худалдаа, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, соёл, хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагааг өргөн хүрээнд бүх талаар эрчимтэй хөгжүүлэхээр тохиров.

Талууд НҮБ, АСЕМ, Азид хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх бага хурал, АСЕАН-ы Бүс нутгийн чуулга, ШХАБ, “Их Түмэн санаачилга” зэрэг олон талт байгууллага болон хамтын ажиллагааны механизмын хүрээн дэх уялдаа, зохицуулалтаа цаашид бататгахаар тохиролцов.

Монголын тал “Торгоны замын эдийн засгийн бүс” санаачилгын хүрээнд хамтран ажиллах, “Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк”-ны бүтээн байгуулалтад үүсгэн байгуулагч улсын хувиар оролцоход бэлэн байгаагаа илэрхийлсэн юм.

Хятадын тал Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн дэвшүүлсэн Зүүн Хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх “Улаанбаатарын яриа хэлэлцээ” санаачилгыг дэмжихээ нотлов.

Энд онцлон тэмдэглэх зүйл бол Монгол Улсын гадаад бодлогын шинэ парадигм бөгөөд тухайлбал, гурван хөршийн Улаанбаатарын дээд хэмжээний уулзалтыг зохион байгуулах санаачилга юм.

2013 оны 10 дугаар сарын 25-нд Бээжин хотод хоёр улсын ерөнхий сайд нарын гарын үсэг зурсан «Монгол Улс, БНХАУ-ын хооронд Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр»-ийн 5.5-д заахдаа: “Талууд Монгол, Хятад, Оросын гурван талын зөвлөлдөх уулзалтын механизмыг үргэлжлүүлэн бэхжүүлэх, дэд сайдын түвшний зөвлөлдөх уулзалтын механизмыг байгуулах асуудлыг урагшлуулахаар санал нэгтэй тохиролцов. Шаардлагатай тохиолдолд гурван талын өндөр түвшний уулзалт зохион байгуулж, Монгол, Хятад, Орос гурван улсын хамтын ажиллагааг улам бүр

урагшлуулна”⁴ гэж заасан нь чухал ач холбогдолтой байв.

2014 оны 8 дугаар сарын 21-ний «Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай Улаанбаатарын хамтарсан Тунхаглал»-ийн *дөрөвт* заахдаа: “Талууд Монголын талын санаачилсан Монгол, Хятад, Орос гурван улсын удирдагчдын уулзалтыг зохион байгуулах, гурван талын яриа хэлэлцээний механизмыг бэхжүүлэх, гурван талын хамтын ажиллагааг эрчимжүүлэхийг дэмжинэ” гэсэн юм.

Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Төрийн тэргүүн нарын “Улаанбаатарын уулзалт”-ын санаачлагыг хэрэгжүүлэх талаархи анхны гурван талт дээд уулзалтыг 2014 оны 9 дүгээр сарын 11-нд Тажикстаны нийслэл Душанбе хотноо амжилттай зохион байгуулав. Үүнээс хойш Монгол улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачлагаар 2015 онд ОХУ-ын Уфа хотноо, улмаар 2016 оны 6-р сард Ташкент хотноо Монгол, Орос, Хятадын ерөнхийлөгч нар гурав дахь удаагаа уулзсан болно. Уулзалтаар Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төрийн тэргүүн нарын “Улаанбаатарын уулзалт”-ын агуулга, зарчмыг хэлэлцэж байх асуудлын тухай Монгол Улсын санаачилгын талаар тийнхүү хэлэлцэж, тодорхой ойлголцол, тохиролцоонд хүрэв. Энэ бол Монгол Улсын гадаад бодлогын шинэ парадигм юм.

Монгол Улс өөрийн хүрээлэн буй геополитикийн орчинд хөрш орнуудтай түншлэлийн харилцааны эрхзүйн үндсийг бүрдүүлсэн гэж үзэж болохоор байна. Монгол Улс 1997 онд Японтой *«Иж бүрэн түншлэл»*, 2010 онд *«Стратегийн түншлэл»*, 1999 онд БНСУ-тай *«Харилцан нөхсөн хамтын ажиллагаа, хөгжлийн түншлэл»*, 2006 онд *«Сайн хөршийн найрамдал, хамтын ажиллагааны түншлэл»*, 2011 онд *«Иж бүрэн түншлэл»*, 2004, 2005 онд АНУ-тай *«Стратегийн түншлэл»*, 2004 онд Канадтай *«Өргөн хүрээтэй түншлэл»*, 2005 онд Турк улстай *«Иж бүрэн түншлэл»*, 2007 онд Австрали улстай *«Өргөтгөсөн түншлэл»*, 2007 онд Казахстантай *«Өргөн хүрээтэй түншлэл»*, 2008 онд ХБНГУ-тай *«Иж бүрэн түншлэл»*, 2009 онд Энэтхэгтэй *«Иж бүрэн түншлэл»*, 2011 онд Украинтай *«Олон талтай хамтын ажиллагааны түншлэл»*, 2013

⁴ Монгол Улс, БНХАУ-ын хооронд Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх Дунд, Урт хугацааны Хөтөлбөр. УБ.: 2013.10.25

онд ЕХ-той «Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр»-ийн харилцааны эрхзүйн баримт бичгүүдийг тус тус байгуулав.

Түншлэлийн харилцаа нь хамтын ажиллагааны ямар нэг хатуу тогтсон үзэл сурталд тулгуурладаггүй, харин улс орнуудын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, дотоод хэрэгт үл оролцох, тэгш эрхтэй, харилцан ашигтай, хөгжлийн нийтлэг эрх ашиг, сонирхлыг тэргүүн зэрэгт тавих, улс бүрийн ялгаатай соёл иргэншил, амьдралын ёс жаягийг ойлгон хүндэтгэх, зөвшлийн үндсэн дээр шийдвэр гаргана гэж үйл ажиллагаандаа баримтлах зарчмаа тодорхойлж байна. Тэгэхлээр түншлэл нь «гуравдагч хөрш»-ийн бодлогын хүрээнд “иж бүрэн” байж болно, “стратегийн” байж болно, “олон талтай”, эсвэл “өргөн хүрээтэй” байж болно, мөн “оюун санааны” түншлэл байж болно. 2011 оны 8 дугаар сард Финландын Ерөнхийлөгч Тарья Халонен Монгол Улсад айлчлах үеэрээ хоёр орны харилцааг *«тэгш эрхтэй түншлэлийн харилцаа»* гэж нэрлэж байв. 2007 оны 4 дүгээр сард Австралийн Гадаад харилцааны сайд А.Даунер Монгол Улсад албан ёсны айлчлал хийх үеэр хоёр улс *«өргөмтгөсөн түншлэл»*-ийн зарчмаар харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар тохиролцсон билээ. Өөрөөр хэлбэл, хоёр тал харилцаа, хамтын ажиллагааны онцлог, ашиг сонирхлоос хамааран түншлэлийн харилцаагаа янз бүрээр тодотгож, томъёолон гаргаж байгаа ч утга агуулга нь хоорондоо адил төстэй юм уу, ижил байдаг. Зарим орон «стратегийн» гэдэг үгнээс зайлсхийдэг.

«Стратегийн түншлэл»-д уламжлалт болон уламжлалт бус аюул, түүний аюулгүй байдлын асуудал, энх тайвныг сахин хангах, олон улсын терроризмын эсрэг тэмцэх, чөлөөт худалдааны хэлэлцээр гол төлөв тусгагдсан байдгаас гадна энэ харилцаа урт хугацаанд тогтвортой, бүх талыг хамран үргэлжилнэ гэсэн санаа хамт явж байдаг байна. Харин энд “холбоотны буюу эвслийн” эрх ашгийг тэргүүн зэрэгт тавих буюу харгалзах, «ах дүүгийн» харилцааны ах нь сургах, дүү нь сонсох агуулга суурилдаггүй бөгөөд үүгээрээ түншлэгч талуудын тэгш эрх хангагдаж буй гэж үзэж болно. Мөн өргөн хамтран ажиллах утга санаа шингэсэн байдаг нь хамтын хариуцлага хүлээдэг. Тэгэхлээр түншлэл нь улс гүрнүүдийн хэвийн, найрсаг харилцаанаас агуулга, хэлбэрээрээ өргөн юм.

Зарим улс орон стратегийн түншлэлийн харилцаанд болгоомжтой ханддаг ч орчин үеийн олон улсын харилцааны шинэ дэг журам бүрэлдэн тогтох үйл явц өрнөж байгаа өнөө үед түншлэл нь гуравдагч этгээдийн эсрэг чиглэсэн шинжтэй байх ёсгүй. Одоо үед түншлэлийн эдийн засгийн утга, агуулга нь улам өргөжин тэлж байна. Нөгөө талд Монгол Улсын орон зайн байршил, байгалийн баялаг хоёр геополитикийн гол хүчин зүйл болов.

В.Путин 2012 оны 3 дугаар сард ОХУ-ын Ерөнхийлөгчөөр гурав дахь удаагаа сонгогдсоны дараа гадаад анхны айлчлалаа мөн оны 6 дугаар сард БНХАУ-аас эхэлж, хоёр орны бүх талыг хамарсан стратегийн түншлэл (*Россия и Китай выходят на новый уровень отношений-уровень всеобъемлющего стратегического партнерства*)-ийг шинэ түвшинд хүргэх тухай “Бээжингийн Тунхаглал”-д гарын үсэг зурсан юм. Энэ нь Монгол Улстай байгуулсан “Хамтарсан Тунхаглал”-ын үзэл санаатай ижил утгатай билээ.

ДҮГНЭЛТ

Нэг, Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачилсан Монгол, Орос, Хятад гурван улсын төрийн тэргүүний уулзалт тогтмол шинжтэй болж, 6 дугаар сард Ташкент хотноо болсон Монгол, Орос, Хятадын төрийн тэргүүн нарын 3 талт уулзалтын үеэр Монголын талаас “Төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх нөхцлийн тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг байгуулах саналаа дэвшүүллээ.

Хоёр, 2016 оны 4 дүгээр сард ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.В.Лавров Монгол Улсад айлчлах үеэр “Монгол-Оросын Стратегийн түншлэлийг хөгжүүлэх Дунд хугацааны хөтөлбөр”-г гарын үсэг зурав. Энэхүү хөтөлбөрийн агуулга нь Монгол Улсын БНХАУ-тай байгуулсан Стратегийн иж бүрэн түншлэл байгуулах хөтөлбөртэй харьцуулан ялгаатай болон ижил төстэй талыг нь судлах хэрэгтэй байна.

Гурав, Монгол Улс нь ОХУ болон БНХАУ-тай стратегийн түншлэлийн харилцаа тогтоон, хөгжүүлж байгаа боловч 1993 оны Монгол Улс, ОХУ-ын Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны

гэрээ, 1994 оны Монгол Улс, БНХАУ-ын Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээг баримтлан харилцсаар ирсэн болно.

Дөрөв, Монгол Улсын Ерөнхийлөгч 2015 оны 9 дүгээр сард Монгол Улс Төвийг сахих статус баримтлах талаар мэдэгдэл гаргасан ч одоогоор байнгын болон байнгын бус төвийг сахих статустай байх эсэхээ тогтоогүй байна. Монгол Улс Төвийг сахих статустай болсон ч өмнөх олон улсын гэрээ хэлэлцээрүүд, гуравдагч хөршийн бодлогоо хэвээр хэрэгжүүлэхээ мэдэгджээ.

Тав, 2015 оны 6-р сард Ташкент хотноо болсон Монгол, Орос, Хятадын төрийн тэргүүн нарын гурван талт уулзалтын үеэр 3 улс дамнасан “Эдийн засгийн коридор” байгуулахаар тохиролцов. Ийнхүү цаашид Монгол Улс, ОХУ, БНХАУ эдийн засгийн хөгжилд илүү анхаарахаар боллоо. Энэ нь гурван улс гурамсан харилцаа хүнд үед Монгол Улсыг “бамбай (жийргэвч)” болгон ашигладаг байсан бол өдгөө Монгол Улс нь гурамсан харилцааны нэн таатай “суваг” болж байна хэмээн дүгнэж болно.